# МОНГОЛ УЛСЫН ГАДААД СЕКТОРЫН ТОЙМ



**ОНЦЛОХ МЭДЭЭ:**

- Монгол Улсын гадагш хийсэн хөрөнгө оруулалтын үлдэгдэл буурч байхад гадаадаас Монголд оруулсан хөрөнгө оруулалтын үлдэгдэл нэмэгдсэн нь хөрөнгө оруулалтын богино позиц нэмэгдэхэд нөлөөлжээ.
- Монгол Улсын нийт гадаад зээлийн үлдэгдэл **21** тэрбум ам.доллар байна.

**АГУУЛГА**


| | |
|---|---|
| Төлбөрийн тэнцэл | 2 |
| Гадаад хөрөнгө оруулалтын позиц | 4 |
| Нийт гадаад зээл | 5 |
| Хавсралт | 6 |



**Валют, эдийн засгийн газрын Төлбөрийн тэнцлийн статистик, судалгааны хэлтэс**

Монголбанк
Бага тойруу 3,
Улаанбаатар 15160
Утас: 976-11-323243, 327086, 327088

Факс: +976-11-327088
Email: bop@mongolbank.mn


## Төлбөрийн тэнцэл (BOP)

2015 оны 1-р улиралд (1-3 сарууд) урсгал данс 43 сая ам.долларын, хөрөнгө ба санхүүгийн данс 127 сая долларын алдагдалтай гарснаар нийт төлбөрийн тэнцэл 271 сая ам.долларын алдагдалтай буюу гадаад валютын албан нөөц уг дүнгээр буурчээ. Статистикийн алдаа ба орхигдуулгын дүн -101 сая ам.доллар байна.
2014 оны 1-р улиралтай харьцуулахад урсгал дансны алдагдал 474 сая ам.доллараар, хөрөнгө ба санхүүгийн дансны ашиг 512 сая ам.доллараар тус тус буурсан үзүүлэлттэй байна.
Хөрөнгө ба санхүүгийн дансыг бүтцээр нь авч үзвэл ШХО-ын ашиг 391 сая ам.доллараар, багцын ХО 393 сая ам.доллараар, бусад ХО–ын алдагдал 277 сая ам.доллараар тус тус буурчээ.

**Дүрслэл 1. Төлбөрийн тэнцэл**




## Гадаад хөрөнгө оруулалтын позиц

Монгол Улсын гадаадад байршуулсан санхүүгийн хөрөнгө (актив) 3000 сая ам.доллар, гадаадад төлөх санхүүгийн өглөг (пассив) 27060 сая ам.долларт тус тус хүрснээр гадаад хөрөнгө оруулалтын позиц улирлын эцэст 24061 сая ам.долларын сөрөг үлдэгдэл буюу богино байна.
Энэ нь Монгол Улс цэвэр дүнгээр гадаадад төлөх санхүүгийн өглөгтэй болохыг харуулж байгаа бөгөөд богино позиц нь өнгөрсөн оны мөн үеэс 12% буюу 2626 сая ам.доллараар нэмэгдсэн.
Үүнд: ШХО-ийн богино позиц 477 сая, багцын ХО 69 сая, бусад ХО-ын эх үүсвэр 1467 сая ам.доллараар тус тус өсч, ГВУН 619 сая ам.доллараар буурсан нь нөлөөлжээ.

**Дүрслэл 2. Гадаад хөрөнгө оруулалтын позиц**




## Гадаад өрийн статистик

Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 2015 оны 1-р улирлын гүйцэтгэлээр 20895 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 5%-иар буюу 953 сая ам.доллараар нэмэгдсэн байна.
Үүнд: Засгийн газар болон Төв банкны гадаад өр өнгөрсөн оны мөн үеэс 15%-иар буюу 702 сая ам.доллараар өсч 5432 сая ам.долларт, хувийн хэвшлийн гадаад өр 2%-иар буюу 251 сая ам.доллараар нэмэгдэн 15463 сая ам.долларт хүрсэн байна.

**Дүрслэл 3. Нийт гадаад өрийн үлдэгдэл**




## Гадаад секторын статистик гэж юу вэ?

Гадаад секторын статистик гэж аливаа улс орны гадаад ертөнцтэй харилцах эдийн засгийн харилцааг үзүүлэгч эдийн засгийн төлбөр тооцооны дансдын урсгал болон үлдэгдлийн мөнгөн үзүүлэлтийг хэлдэг.

Энэхүү үзүүлэлтэд төлбөрийн тэнцэл, гадаад хөрөнгө оруулалтын позиц, гадаад зээл, гадаад валютын улсын нөөцийн мэдээ зэрэг статистик мэдээллүүд багтдаг.

**Дүрслэл 4. Статистик хамаарал**



# I. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

## УРСГАЛ ДАНС

Тайлант улиралд урсгал тэнцлийн алдагдал 43 сая ам.доллар гарч, алдагдлын хэмжээ 2014 оны мөн үеэс 92%-иар буурчээ.

Бараа, үйлчилгээний худалдааны алдагдал өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 574 сая ам долларaар өссөн нь барааны алдагдал 371 ам.доллараар, үйлчилгээний алдагдал 203 сая ам.доллараар өссөнөөр тайлбарлагдаж байна.

## Барааны худалдаа

Төлбөрийн тэнцэл дэх барааны худалдааны эргэлт өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 10%-иар буурч 1712 сая ам.долларт хүрсэн. Барааны худалдааны тэнцэл тайлант хугацаанд эерэг тэмдэгтэй 444 сая ам.долларт хүрч, 5 улирал дараалан ашигтай гарлаа.

Барааны худалдааны тэнцэл сайжрахад зэсийн баяжмалын экспортын өсөлт болон хүнд даацын машин, механизм, тоног төхөөрөмж, бүх төрлийн автомашин, нефтийн бүтээгдэхүүний импортын бууралт зэрэг нь голлон нөлөөлсөн.

## Үйлчилгээний худалдаа

Тайлант улирлын үйлчилгээний худалдааны алдагдал өнгөрсөн оны 1 дүгээр улиралтай харьцуулахад 44%-иар буурч 260 сая ам. долларт хүрсэн байна.

Алдагдал ийнхүү буурахад тээврийн зардал 31%-иар буюу 48 сая ам.доллараар, аялалын зардал 14%-иар буюу 18 сая ам.доллараар, бусад үйлчилгээний зардал 47%-иар буюу 136 сая ам.доллараар тус тус буурсан нь голчлон нөлөөлжээ.

Бусад үйлчилгээний хамгийн их хувийг эзэлж байсан бизнесийн удирдлагын зөвлөх үйлчилгээний зардал 72%-иар буюу 63 сая ам.доллараар буурчээ.

## Орлого

Хөрөнгө оруулалтын орлогын данс 229.6 сая ам.долларын алдагдалтай гарч 2013 оны мөн үетэй харьцуулахад алдагдлын хэмжээ 52%-иар өсөв.

Үүнд: Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, байгууллагуудаас харьяат бус хувьцаа эзэмшигчиддээ 55 сая ам.долларын ноогдол ашгийг хуваарилж, гадны хөрөнгө оруулагчдаасаа авсан зээлийн эх үүсвэрт 118 сая ам.долларын хүү төлсөн бол Засгийн газар гадаадаас авсан зээлийн эх үүсвэрийн хүүгийн төлбөрт 6 сая ам.доллар, банкууд зээл, харилцах дансны хүүгийн төлбөрт 10 сая ам.доллар, ААНБ 30 сая ам.долла, төр болон хувийн хэвшлийн гаргасан бондын хүүгийн төлбөрт 46 сая ам.долларыг тус тус төлжээ.

Гадаад ажилтнуудад олгосон цалин хөлсний хэмжээ 22 сая ам.долларт хүрснээс шалтгаалан ажиллагсдын цалин хөлсны данс цэвэр дүнгээр 10 сая ам.долларын алдагдалтай гарсан нь 2014 оны мөн үеэс 49%-иар буурсан үзүүлэлт юм.

Улмаар цэвэр орлогын дансны алдагдал 240 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 40%-иар өссөн байна.

## Урсгал шилжүүлэг

Гадаадын улс орнуудад ажиллаж, амьдарч буй иргэдээс хүлээн авсан гуйвуулгын дүн өмнөх оны мөн үеэс 22%-иар, гадаадын улс орнууд руу шилжүүлсэн хувийн гуйвуулгын хэмжээ 5%-иар тус тус буурснаар ажилчдын гуйвуулга цэвэр дүнгээр 3 сая ам.доллар болж 77%-иар буурсан байна.

**Хүснэгт 1. Урсгал тэнцэл (сая $)**

| Үзүүлэлт | 1-р улирал | | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|
| | 2014 | 2015 | Дүн | Хувь |
| **I. Урсгал тэнцэл** | **-518** | **-43** | **474** | **-92%** |
| ***А. Бараа, үйлчилгээний худалдаа*** | **-390** | **184** | **574** | **-147%** |
| *а. Бараа* | 72 | 444 | 371 | 513% |
| *б. Үйлчилгээ* | -463 | -260 | 203 | -44% |
| ***Б. Цэвэр орлого*** | **-171** | **-240** | **-69** | **40%** |
| ***В. Урсгал шилжүүлэг*** | **44** | **13** | **-31** | **-71%** |

**Дүрсэлэл 5. Барааны худалдаа**




**Дүрслэл 6. Үйлчилгээний худалдаа**




**Хүснэгт 2. Ажилчдын гуйвуулга, (улсаар, мянган ам.доллар)**

| | Хүлээн авсан | | | Шилжүүлсэн | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Мөнгөн дүн | Хувийн жин | Өсөлт | Мөнгөн дүн | Хувийн жин | Өсөлт |
| **Солонгос** | 12 188 | 31% ▲ | 2% | 2 275 | 6% ▼ | -30% |
| **Америк** | 4 993 | 13% ▲ | 1% | 8 433 | 23% ▲ | 65% |
| **Хятад** | 2 663 | 7% ▼ | -14% | 6 650 | 18% ▼ | -20% |
| **Гонг Конг** | 1 298 | 3% ▼ | -28% | 3 112 | 9% ▲ | 54% |
| **Англи** | 2 981 | 8% ▼ | -67% | 1 027 | 3% ▼ | -18% |
| **ОХУ** | 1 184 | 3% ▼ | -41% | 1 514 | 4% ▲ | 11% |
| **Сингапур** | 709 | 2% ▼ | -29% | 724 | 2% ▲ | 339% |
| **Швейцарь** | 1 841 | 5% ▲ | 3% | 1 980 | 5% ▲ | 118% |
| **Герман** | 1 281 | 3% ▲ | 24% | 729 | 2% ▼ | -32% |
| **Япон** | 691 | 2% ▼ | -21% | 920 | 3% ▼ | -1% |
| **Бусад** | 8 870 | 23% ▼ | -25% | 8 734 | 24% ▼ | -37% |
| **НИЙТ** | **38 701** | **100%** | | **36 098** | **100%** | |

**Хүснэгт 3. Ажилчдын гуйвуулга, (IV улирал, сая $)**

| | 2013 | 2014 | 2015 | Жилийн өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Мөнгөн дүн | Хувиар |
| **Ажилчдын гуйвуулга (цэвэр)** | 0,9 | 11,2 | 2,6 | -8,6 | -77% |
| **Гаднаас орж ирсэн** | 51,9 | 49,3 | 38,7 | -10,6 | -21,6% |
| **Гадагш шилжүүлсэн** | -51,0 | -38,2 | -36,1 | 2,08 | -5,4% |

# I. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

## ХӨРӨНГӨ, САНХҮҮГИЙН ДАНС

Тайлант улиралд Хөрөнгө ба санхүүгийн тэнцэл 127 сая ам.долларын алдагдалтай гарч өнгөрсөн оны мөн үеэс 512 сая ам.доллараар буурсан байна.

### Гадаадын шууд хөрөнгө оруулалт

Тайлант хугацаанд гадаадын шууд хөрөнгө оруулалт цэвэр дүнгээр –111 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеийн үзүүлэлтээс 391 сая ам.доллараар буурчээ.

Гадаадын шууд хөрөнгө оруулалт цэвэр дүнгээр ийнхүү буурахад:

1) Дүрмийн санд оруулсан хөрөнгө оруулалт өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 1%-иар буюу 1 сая ам.доллараар буурч, 54 сая ам.долларт
2) Компанийн эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлэх зорилготой зээлийн эх үүсвэрийн санхүүжилт 464 сая ам.доллараар буурч, -130 сая ам.долларт хүрсэн нь тус тус нөлөөлсөн байна.

Тайлант хугацаанд аж ахуйн нэгжүүдийн толгой компаниас авсан зээлийн эргэн төлөлт их хэмжээгээр хийгдсэн тул гадаадын шууд хөрөнгө оруулалтын урсгал сөрөг дүнтэй гарлаа. Түүнчлэн гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгалд жинтэй хувь нэмэр эзэлдэг БНХАУ, Гонг Конгоос хийгдсэн хөрөнгө оруулалт өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад харгалзан 84%, 93%-иар буурчээ.

### Багцын хөрөнгө оруулалт

Багцын хөрөнгө оруулалтын данс тайлант хугацаанд 9 сая ам.долларын алдагдалтай гарахад:

(I) манай иргэд, аж ахуйн нэгжүүд гадны хуулийн этгээдийн хувьцаа, үнэт цаасыг худалдаж авахад 8 сая ам.долларыг зарцуулсан,
(II) гадны иргэд, аж ахуйн нэгжүүд эдийн засгийн харъяатын хөрөнгийн хувьцааг худалдаж авахад 0.2 сая ам.долларыг төлж (орох урсгал), бонд, үнэт цаасыг 0.8 сая ам.доллараар худалдаж авснаар (орох урсгал) пассив 1 сая ам.долларт хүрсэн нь нөлөөлсөн байна.

### Бусад хөрөнгө оруулалт

Тайлант улиралд бусад хөрөнгө оруулалтын данс 25 сая ам.долларын алдагдалтай гарсан бөгөөд үүнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал алдагдал 277 сая ам.доллараар буурсан үзүүлэлт юм. Энэ нь Хятадын Ардын Банкны своп хэлцлийн ашиглалт 321 сая ам.доллараар нэмэгдэж, аж ахуйн нэгж, иргэдийн гадаадын банк, санхүүгийн байгууллага байршуулсан болон гар дээрх бэлэн мөнгө өмнөх оны мөн үеэс 106 сая ам.доллараар буурснаар голчлон шалтгаалжээ.

### Алдаа ба орхигдуулга

Тайлант хугацаанд алдаа ба орхигдуулга үзүүлэлт –101 сая ам.доллар гарсан байна.

Уг үзүүлэлт сөрөг дүнтэй гарсан нь тайлант хугацаанд гадагш чиглэсэн хөрөнгийн урсгалын төлбөр тооцоо дутуу бүртгэгдэж байж болзошгүйг харуулж байна.

**Хүснэгт 4. Хөрөнгө, санхүүгийн тэнцэл (сая $)**

| Үзүүлэлт | 1-р улирал | | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|
| | 2014 | 2015 | Дүн | Хувь |
| **II. Хөрөнгө, санхүүгийн тэнцэл** | **385** | **-127** | **-512** | **-133%** |
| ***А. Хөрөнгийн данс*** | **24** | **18** | **-6** | **-23%** |
| ***Б. Санхүүгийн данс*** | **361** | **-145** | **-506** | **-140%** |
| *а. Шууд хөрөнгө оруулалт* | 279 | -111 | -391 | -140% |
| *Гадагш хийсэн* | -4 | -2 | -2 | -52% |
| *Монгол Улсад орсон* | 283 | -109 | -393 | -139% |
| *б. Багцын хөрөнгө оруулалт* | 384 | -9 | -392 | -102% |
| *в. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл* | 0 | 0 | 0 | |
| *г. Бусад хөрөнгө оруулалт* | -302 | -25 | -277 | -92% |
| *Үүнээс: Худалдааны зээл* | -132 | -201 | 69 | -18x |
| *Бэлэн мөнгө харилцах* | -309 | 205 | -514 | -166% |

**Хүснэгт 5. Монгол улсад орсон ШХО (сая $)**

| Үзүүлэлт | 2015 он 1-р улирал | | 2015Q1/2014Q1 |
|---|---|---|---|
| | Мөнгөн дүн | Хувийн жин | Өөрчлөлт % |
| БНХАУ | 8.4 | -4% | -84% ▼ |
| Өмнөд Солонгос | 10.5 | -6% | 21% ▲ |
| Канад | 1.9 | -1% | -69% ▼ |
| Гонг Конг | 19.0 | -10% | -93% ▼ |
| Япон | 5.0 | -3% | -84% ▼ |
| ОХУ | -1.4 | 1% | -115% ▼ |
| Англи | -4.3 | 2% | -147% ▼ |
| АНУ | 7.1 | -4% | 12% ▲ |
| Европ тив (Англи, ХБНГУ-аас бусад) | 0.7 | 0% | 8% ▲ |
| Австрали | 2.2 | -1% | -62% ▼ |
| ХБНГУ | 0.5 | 0% | -88% ▼ |
| Сингапур | 9.2 | -5% | -45% ▼ |
| Бусад | -134.3 | 71% | -2749% ▼ |
| Орлогын дахин хөрөнгө оруулалт | -33.7 | 18% | |
| **Нийт** | **-109.2** | **58%** | |

**Дүрслэл 7. Бусад хөрөнгө оруулалт (сая $)**




**Дүрслэл 8. Улсын гадаад валютын нийт албан нөөц**



# II. ГАДААД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ПОЗИЦ

Монгол Улсын Гадаад хөрөнгө оруулалтын позиц (цэвэр) 2015 оны 1-р улирлын эцэст –24061 сая ам.доллар байв.

Өөрөөр хэлбэл, Монгол Улсын гаднаас татсан хөрөнгө оруулалтын хэмжээ нь гадагш хийсэн хөрөнгө оруулалтаас 24 тэрбум ам.доллараар их байна. Энэ нь гадаадын шууд хөрөнгө оруулалт, багцын болон бусад хөрөнгө оруулалт, ялангуяа ГШХО-тай аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулагчаасаа татсан зээлийн санхүүжилтийн үлдэгдлээс голлон хамаарч байна.

Монгол Улсаас эдийн засгийн харьяат бус оруулсан хөрөнгө оруулалтын дүн (актив) 3000 сая ам.доллар байна. Үүний 44%-ийг гадаад валютын албан нөөц, 34%-ийг бусад хөрөнгө оруулалтын актив, 12%-ийг шууд хөрөнгө оруулалт, үлдсэн 10%-ийг багцын хөрөнгө оруулалт тус тус эзэлж байна.

Монгол Улсын эдийн засгийн харьяатад Гадаадаас оруулсан хөрөнгө оруулалтын дүн (пассив) 27060 сая ам.долларт хүрчээ. Үүний 61%-ийг гадаадын шууд хөрөнгө оруулалт, 28%-ийг бусад хөрөнгө оруулалт, үлдсэн 11%-ийг багцын хөрөнгө оруулалт тус тус эзэлж байна.

Монгол Улс дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтын 37%-ийг буюу 6073 сая ам.долларыг хувь нийлүүлэгчийн дүрмийн сан дахь хөрөнгө оруулалт, үлдсэн 63% буюу 10534 сая ам.долларыг толгой компаниасаа авсан зээл (компани хоорондын өглөг, санхүүжилт) эзэлж байна.

Гадаад хөрөнгө оруулалтын богино позиц өмнөх оны мөн үеэс 12%-иар буюу 2636 сая ам.доллараар нэмэгдсэн байна. Үүнийг:

- Ерөнхий бүтцээр нь авч үзвэл, гадаад актив 23%-иар буюу 911 сая ам.доллараар буурч, гадаад пассив 7%-иар буюу 1725 сая ам.доллараар өссөн,
- Данс тус бүрээр авч үзвэл, гадаадын шууд хөрөнгө оруулалтын богино позиц 477 сая ам.доллараар, багцын хөрөнгө оруулалтын богино позиц 69 сая ам.доллараар, бусад хөрөнгө оруулалт богино позиц 1467 сая ам.доллараар тус тус нэмэгдэж, харин ГВАН 619 сая ам.доллараар буурч,

**Хүснэгт 7. Позиц (сая ам.доллар)**

| Үзүүлэлт | 3/31/2014 | 3/31/2015 | Өөрчлөлт: Дүн | Өөрчлөлт: Хувь |
|---|---|---|---|---|
| **Гадаад хөрөнгө оруулалтын позиц** | **-21,425** | **-24,061** | **-2,636** | **12%** |
| **I. Гадаад актив** | **3,911** | **3,000** | -911 | -23% |
| 1. Шууд хөрөнгө оруулалт | 259 | 367 | 108 | 42% |
| 2. Багцын хөрөнгө оруулалт | 324 | 288 | -35 | -11% |
| 3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл | 5 | 1 | -4 | -74% |
| 4. Бусад хөрөнгө оруулалт | 1,379 | 1,019 | -360 | -26% |
| 5. Нөөц актив | 1,943 | 1,324 | -619 | -32% |
| **II. Гадаад пассив** | **25,335** | **27,060** | **1,725** | **7%** |
| 1. Шууд хөрөнгө оруулалт | 16,022 | 16,607 | 585 | 4% |
| 2. Багцын хөрөнгө оруулалт | 2,872 | 2,906 | 34 | 1% |
| 3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл | 5 | 4 | -1 | -10% |
| 4. Бусад хөрөнгө оруулалт | 6,437 | 7,543 | 1,107 | 17% |

**Дүрслэл 9. Гадаад актив**




**Дүрслэл 10. Гадаад пассив**




## Хөрөнгийн зах зээлийн үнэ

Монгол Улсад хөрөнгө оруулсан, Олон улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй аж ахуйн нэгжүүдийн хувьцааны үнэ 2015 оны 1-р улиралд өмнөх улирлын хаалтын ханштай харьцуулахад дунджаар 33%-иар өсчээ.

Петро Матад компанийн хувьцаа 171.2%-иар өсч 5.75 канад доллар болсон бол Саусгоби сэндс компаний хувьцаа 46.9%-иар өсч 5.67 хонгконг долларт хүрсэн байна. Харин Харанга ресурс, Пийс Мап Холдинг, Монголиа Майнинг корпораци, Монголиа Энержи корпораци, Винсвэй Кокинг кол зэрэг компаниудын хувьцааны ханш уналттай байна.

**Хүснэгт 8. Олон улсын хөрөнгийн бирж дээрх хувьцааны үнэ**

| № | Компанийн нэр | Симбол | Бирж | Мөнгөн тэмдэгт | Хаалтын үнэ 14.12.31 | Хаалтын үнэ 15.03.31 | Өөрчлөлт |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Turquoise Hill Resources | TRQ:US | US | USD | 3,10 | 3,12 | 0,6% |
| 2 | Mongolian Mining Corp | 0975.HK | HK | HKD | 0,34 | 0,28 | -17,6% |
| 3 | Centerra Gold | CG.TO | CAD | CAD | 6,04 | 6,18 | 2,3% |
| 4 | Southgobi Resources | 1878.HK | HK | HKD | 3,86 | 5,67 | 46,9% |
| 5 | Winsway Cocking Coal | 1733.HK | HK | HKD | 0,25 | 0,23 | -6,4% |
| 6 | Mongolia Energy Corp | 0276.HK | HK | HKD | 0,40 | 0,34 | -15,0% |
| 7 | Petro Matad | MATD.L | LN | GBP | 2,12 | 5,75 | 171,2% |
| 8 | Prophecy Coal Corp | PCY.TO | CAD | CAD | 0,05 | 0,05 | 0,0% |
| 9 | Haranga resources | HAR.AX | AU | AUD | 0,01 | 0,01 | -30,0% |
| 10 | Peace Map Holding Limited | 0402.HK | HK | HKD | 0,34 | 0,27 | -22,1% |

# III. ГАДААД ӨРИЙН СТАТИСТИК

Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 2015 оны 1-р улирлын байдлаар 20895 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 953 сая ам.доллараар нэмэгдсэн байна. Үүнийг салбараар нь авч үзвэл:

**Улсын салбар:** Засгийн газар, Монголбанкны гадаад өр 702 сая ам.доллараар нэмэгдэж 5432 сая ам.долларт хүрчээ.

**Хувийн хэвшил:** Банк, бусад сектор, хөрөнгө оруулагчийн зээлийг бүхэлд нь хувийн хэвшлийн салбарын гадаад өр гэж ойлгох бөгөөд өнгөрсөн жилийн хугацаанд 251 сая ам.доллараар нэмэгдэж 15463 сая ам.долларт хүрээд байна.

**Хүснэгт 9. Нийт гадаад өрийн үлдэгдэл (сая ам.доллар)**

| Үзүүлэлт | 3/31/2014 | 3/31/2015 | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|
| | | | Дүн | Хувь |
| **Нийт гадаад өр** | **19,942** | **20,895** | **953** | **5%** |
| **I. Засгийн газар** | **3,688** | **3,556** | **-132** | **-4%** |
| **II. Төв банк** | **1,042** | **1,876** | **834** | **80%** |
| **III. Банк** | **1,453** | **1,577** | **125** | **9%** |
| Богино хугацаат | 198 | 290 | 92 | 46% |
| Урт хугацаат | 1,254 | 1,287 | 33 | 3% |
| **IV. Бусад сектор** | **3,094** | **3,352** | **258** | **8%** |
| Богино хугацаат | 455 | 392 | -63 | -14% |
| Урт хугацаат | 2,640 | 2,961 | 321 | 12% |
| **V. Хөрөнгө оруулагчаас авсан зээл** | **10,665** | **10,533** | **-132** | **-1%** |

## Банкны салбар

Банкны салбарын гадаад пассивын үлдэгдэл 2015 оны эхний улирлын байдлаар 1577 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 9%-иар буюу 125 сая ам.доллараар нэмэгджээ.

Гадаад пассивын 45%-ийг урт хугацаат зээл, 30%-ийг бонд, өрийн бичиг, 18%-ийг богино хугацаат зээл, үлдсэн 7%-ийг оршин суугч бусын харилцах, хадгаламжийн дансны өглөг тус тус бүрдүүлж байна.

Банкууд тайлант улиралд гадаадын банк, санхүүгийн байгууллагаас 50 сая ам.долларын урт хугацаат, 9 сая ам.долларын богино хугацаат зээлийг шинээр авч, зээлийн гэрээнд заасан хуваарийн дагуу харгалзан 37 сая ам.доллар, 32 сая ам.долларын үндсэн төлбөрийг буцаан төлснөөр зээлийн үлдэгдэл 711 сая ам.доллар, 290 сая ам.долларт тус тус хүрчээ.

**Дүрслэл 11. Банкны салбарын гадаад зээл**




## Банкны бус салбар

Банк бус салбарын буюу аж ахуйн нэгж, иргэдийн гадаад пассив 2015 оны 1-р улирлын эцэст 13886 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 1%-иар буюу 126 сая ам.доллараар нэмэгдсэн.

Салбарын нийт зээлийн 76% буюу 10533 сая ам.долларын эх үүсвэр нь аж ахуйн нэгж, байгууллагуудын гадаадын хөрөнгө оруулагчийн зээл буюу компани хоорондын өглөг бөгөөд үүний дийлэнх нь уул уурхайн салбарт ашиглагдсан байна. Эх үүсвэр нь компаний эргэлтийн хөрөнгө, мөнгөн урсгалыг дэмжих зорилгоор олгогддог урт хугацаат санхүүжилт бөгөөд ихэнх тохиолдолд хүүгүй, хатуу мөрдөх эргэн төлөлтийн хуваарь үгүй, улмаар харилцан тохиролцсоны үндсэн дээр цаашид дүрмийн санд нэмж тооцогдох боломжтой байдгаараа бусад төрлийн зээлээс ялгаатай юм.

Хөрөнгө оруулагчдын санхүүжилтийн ашиглалт болон буцаан төлөлтийн байдлыг авч үзвэл тайлант улиралд харгалзан 193 сая ам.доллар, 323 сая ам.доллар байжээ.

ААНБ-уудын экспортын бараа, үйлчилгээнд авсан урьдчилгаа төлбөр болон төлбөрийг хийгээгүй боловч хүлээн авсан импортын бараа үйлчилгээний урт, богино хугацаат өглөгийн үлдэгдэл тайлант улирлын байдлаар 351 сая ам.доллар болсон байна.

**Дүрслэл 12. Банк бус хувийн хэвшлийн гадаад зээл**




**Мэдээллийн эх сурвалж:**

1. Засгийн газрын гадаад өр: Сангийн яам, Өрийн удирдлагын хэлтэс
2. Монголбанк: Монголбанк, ТТБГазар, ВЭЗГазар
3. Банк: Арилжааны банкуудын тайлан тэнцэл, Төлбөрийн тэнцлийн мэдээ, Гадаад зээлийн бүртгэл
4. Банк бус салбар: ААН-ийн Төлбөрийн тэнцлийн улирлын мэдээ, Банкуудын гадаад гүйлгээний тайлан, Гадаад зээлийн бүртгэлийн мэдээллийг тус тус ашиглав.

# ХАВСРАЛТ 1. МОНГОЛ УЛСЫН ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН ХУРААНГУЙ ХҮСНЭГТ (сая ам.доллар)

| Үзүүлэлт | 1 дүгээр улирал | | | Өөрчлөлт | | | | Дундаж, сүүлийн | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2013 | 2014 | 2015 | Дүн | 2014/13 | Дүн | 2015/14 | 3 сар | 6 сар | 9 сар |
| **I. Урсгал Тэнцэл** | **-772** | **-518** | **-43** | **254** | **-33%** | **474** | **-92%** | **8** | **-18** | **-42** |
| **А. Бараа ба үйлчилгээний худалдаа** | **-615** | **-390** | **184** | **225** | **-37%** | **574** | **-147%** | **86** | **63** | **39** |
| **1. Бараа** | **-235** | **72** | **444** | **308** | **-131%** | **371** | **513%** | **185** | **174** | **149** |
| 1.1 Ерөнхий эд бараа | -269 | 20 | 353 | 289 | -107% | 333 | 1685% | 134 | 129 | 107 |
| Экспорт Ф.О.Б. (Кредит) | 766 | 897 | 980 | 131 | 17% | 83 | 9% | 392 | 444 | 465 |
| Үүнээс: Зэсийн | 839 | 949 | 512 | 110 | 13% | -437 | -46% | 217 | 248 | 247 |
| Импорт Ф.О.Б. (Дебит) | -1 035 | -877 | -627 | 158 | -15% | 250 | -29% | -258 | -315 | -358 |
| Үүнээс: Нефтийн | -1 354 | -1 301 | -154 | 53 | -4% | 1 147 | -88% | -68 | -83 | -89 |
| Хүнсний | -417 | -471 | -84 | -54 | 13% | 386 | -82% | -35 | -38 | -39 |
| 1.2 Мөнгөжөөгүй алт | 43 | 90 | 98 | 47 | 110% | 8 | 9% | 54 | 48 | 46 |
| Кредит | 43 | 90 | 98 | 47 | 110% | 8 | 9% | 54 | 48 | 46 |
| Дебит | 0 | 0 | 0 | 0 | 0% | 0 | 0% | 0 | 0 | 0 |
| 1.3 Бусад | -9 | -37 | -7 | -28 | 323% | 30 | -80% | -2 | -6 | -2 |
| Кредит | 0 | 1 | 0 | 1 | 254% | -1 | -100% | 0 | 0 | 0 |
| Дебит | -9 | -38 | -7 | -29 | 321% | 31 | -81% | -3 | -3 | -4 |
| **2. Үйлчилгээ** | **-380** | **-463** | **-260** | **-82** | **22%** | **203** | **-44%** | **-100** | **-111** | **-111** |
| 2.1 Тээвэр | -153 | -108 | -60 | 45 | -29% | 48 | -44% | -25 | -30 | -32 |
| Кредит | 45 | 45 | 45 | 0 | 0% | 0 | 0% | 16 | 16 | 17 |
| Дебит | -198 | -153 | -105 | 45 | -23% | 48 | -31% | -41 | -47 | -49 |
| 2.2 Аялал | -75 | -110 | -93 | -34 | 45% | 17 | -15% | -33 | -32 | -26 |
| Кредит | 17 | 19 | 18 | 2 | 14% | -1 | -5% | 6 | 9 | 16 |
| Дебит | -92 | -129 | -111 | -36 | 40% | 18 | -14% | -39 | -41 | -42 |
| 2.3 Бусад үйлчилгээ | -152 | -245 | -107 | -93 | 61% | 138 | -56% | -41 | -49 | -53 |
| Кредит | 46 | 45 | 46 | -1 | -2% | 2 | 4% | 15 | 15 | 17 |
| Дебит | -197 | -290 | -154 | -92 | 47% | 136 | -47% | -56 | -65 | -70 |
| **В. Орлого** | **-182** | **-171** | **-240** | **11** | **-6%** | **-69** | **40%** | **-83** | **-88** | **-89** |
| 1. Ажиллагсдын цалин хөлс | -48 | -20 | -10 | 28 | -58% | 10 | -49% | -7 | -10 | -10 |
| Кредит | 12 | 15 | 12 | 3 | 26% | -3 | -23% | 4 | 4 | 4 |
| Дебит | -60 | -35 | -22 | 25 | -42% | 13 | -38% | -11 | -14 | -14 |
| 2. Хөрөнгө оруулалтын орлого | -134 | -151 | -230 | -17 | 13% | -79 | 52% | -75 | -78 | -79 |
| Кредит | 2 | 1 | 1 | -1 | -44% | 0 | 3% | 0 | 0 | 0 |
| Дебит | -136 | -152 | -230 | -16 | 12% | -79 | 52% | -76 | -78 | -79 |
| **С. Урсгал шилжүүлэг (цэвэр)** | **26** | **44** | **13** | **18** | **68%** | **-31** | **-71%** | **5** | **7** | **8** |
| Кредит | 79 | 85 | 51 | 5 | 7% | -33 | -39% | 19 | 21 | 23 |
| Дебит | -53 | -41 | -39 | 12 | -23% | 2 | -6% | -14 | -14 | -15 |
| Үүнээс: Ажиллагсдын гуйвуулга | 1 | 11 | 3 | 10 | 1135% | -9 | -77% | 1 | 2 | 1 |
| Кредит | 52 | 49 | 39 | -3 | -5% | -11 | -22% | 14 | 15 | 16 |
| Дебит | -51 | -38 | -36 | 13 | -25% | 2 | -5% | -12 | -13 | -14 |
| **II. Хөрөнгө ба Санхүүгийн Тэнцэл** | **658** | **385** | **-127** | **-272** | **-41%** | **-512** | **-133%** | **19** | **54** | **56** |
| **А. Хөрөнгийн данс** | **26** | **24** | **18** | **-2** | **-8%** | **-6** | **-23%** | **8** | **8** | **8** |
| **В. Санхүүгийн данс** | **632** | **361** | **-145** | **-270** | **-43%** | **-506** | **-140%** | **11** | **46** | **47** |
| **1. Шууд хөрөнгө оруулалт** | **844** | **279** | **-111** | **-565** | **-67%** | **-391** | **-140%** | **-27** | **-47** | **-16** |
| 1.1 Гадагш хийсэн | -2 | -4 | -2 | -2 | 130% | 2 | -52% | -30 | -15 | -11 |
| 1.1.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө | -2 | -4 | -2 | -2 | 104% | 2 | -46% | -30 | -15 | -11 |
| 1.1.2 Орлогын дахин хөрөнгө | 0 | 0 | 0 | 0 | 0% | 0 | 0% | 0 | 0 | 0 |
| 1.1.3 Бусад хөрөнгө | 0 | 0 | 0 | 0 | 0% | 0 | 0% | 0 | 0 | 0 |
| 1.2 Монголд орсон | 846 | 283 | -109 | -562 | -66% | -393 | -139% | 3 | -32 | -5 |
| 1.2.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө | 147 | 55 | 54 | -92 | -62% | -1 | -1% | 24 | 24 | 25 |
| 1.2.2 Орлогын дахин хөрөнгө | -6 | -106 | -34 | -100 | 1681% | 73 | -68% | -14 | -17 | -17 |
| 1.2.3 Бусад хөрөнгө | 705 | 335 | -130 | -370 | -53% | -464 | -139% | -7 | -39 | -12 |
| **2. Багцын хөрөнгө оруулалт** | **-2** | **384** | **-9** | **386** | **-16588%** | **-392** | **-102%** | **-6** | **-20** | **-12** |
| 2.1 Актив | -10 | -6 | -8 | 4 | -37% | -2 | 26% | -7 | -5 | -3 |
| 2.1.1 Хөрөнгийн хувьцаа | -5 | -6 | -8 | -1 | 14% | -2 | 28% | -7 | -5 | -3 |
| 2.1.2 Өрийн бичиг | -5 | 0 | 0 | 4 | -74x | 0 | -0,22311 | 0 | 0 | 0 |
| 2.2 Пассив | 7 | 390 | -1 | 383 | 5157% | -391 | -35x | 2 | -14 | -9 |
| 2.2.1 Хөрөнгийн хувьцаа | 1 | -2 | 0 | -3 | -262% | 2 | -99% | 0 | 0 | -1 |
| 2.2.2 Өрийн бичиг | 6 | 392 | -1 | 386 | 6196% | -393 | -100% | 2 | -14 | -8 |
| **3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл** | **0** | **0** | **0** | **0** | **0%** | **0** | **0%** | **0** | **0** | **0** |
| 3.1 Актив | 0 | 0 | 7 | 0 | 0% | 8 | 0% | 0 | 1 | 2 |
| 3.2 Пассив | 0 | 1 | -8 | 1 | 0% | -8 | 0% | 0 | 0 | 0 |
| **4. Бусад хөрөнгө оруулалт** | **-210** | **-302** | **-25** | **-92** | **44%** | **277** | **-92%** | **43** | **113** | **75** |
| 4.1 Актив | -302 | -442 | -69 | -140 | 46% | 373 | -84% | 7 | -24 | -48 |
| 4.1.1 Худалдааны зээл | 37 | -129 | 18 | -166 | -447% | 147 | -114% | 5 | 5 | 4 |
| 4.1.2 Зээл | 0 | 0 | 0 | 0 | -97% | 0 | 2734% | 0 | 0 | -5 |
| 4.1.3 Бэлэн мөнгө ба харилцах | -338 | -313 | -86 | 25 | -7% | 227 | -72% | 3 | -29 | -47 |
| 4.1.4 Бусад актив | 0 | 0 | 0 | 0 | 0% | 0 | 0% | 0 | 0 | 0 |
| 4.2 Пассив | 92 | 140 | 44 | 48 | 52% | -96 | -69% | 36 | 137 | 123 |
| 4.2.1 Худалдааны зээл | 41 | -3 | -219 | -44 | -108% | -216 | 6703% | -51 | -25 | -14 |
| 4.2.2 Зээл | 41 | 138 | -17 | 97 | 237% | -155 | -112% | 49 | 75 | 63 |
| 4.2.3 Бэлэн мөнгө ба харилцах | 9 | 5 | 291 | -5 | -52% | 287 | 6318% | 46 | 81 | 70 |
| 4.2.4 Бусад пассив | 0 | 0 | -12 | 0 | 0% | -12 | 0% | -8 | 6 | 4 |
| **III. Алдаа болон орхигдуулга** | **-283** | **-175** | **-101** | **108** | **-38%** | **74** | **-42%** | **15** | **-10** | **-28** |
| *Төлбөрийн тэнцлийн нийт дүн* | *-398* | *-308* | *-271* | *90* | | *37* | *-12%* | *42* | *26* | *-14* |
| **IV. Гадаад валютын цэвэр нөөцийн өөрчлөлт*** | **398** | **308** | **271** | **-90** | **-23%** | **-37** | **-12%** | **-42** | **-26** | **14** |
| **1. Актив** | **419** | **332** | **274** | **-88** | | **-58** | | **-34** | **-32** | **10** |
| 1.1 Мөнгөжсөн алт | 0 | 39 | 0 | 39 | | -39 | | 0 | 0 | 0 |
| 1.2 Зээлжих тусгай эрх | 0 | 0 | 0 | 0 | | 0 | | 0 | 0 | 0 |
| 1.3 ОУВС-д байршуулсан хөрөнгө | 0 | 0 | 0 | 0 | | 0 | | 0 | 0 | 0 |
| 1.4 Бэлэн валют ба харилцах | 419 | 292 | 274 | -127 | | -18 | | -34 | -32 | 10 |
| 1.5 Бусад нөөц актив | 0 | 0 | 0 | 0 | | 0 | | 0 | 0 | 0 |
| **2. Пассив** | **-22** | **-24** | **-3** | **-2** | | **21** | | **-8** | **6** | **4** |
| 2.1 ОУВС-ийн зээл | -22 | -24 | -3 | -2 | | 21 | | -8 | 6 | 4 |
| 2.2 Онцгой санхүүжилт | 0 | 0 | 0 | 0 | | 0 | | 0 | 0 | 0 |

** [-] утга нь өсөлтийг, [+] утга нь бууралтыг тус тус илэрхийлнэ.*

## ХАВСРАЛТ 2. ГАДААД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ПОЗИЦИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН (мянган ам.доллар)

| Үзүүлэлт | 11.03.31 | 12.03.31 | 13.03.31 | 14.03.31 | 14.06.30 | 14.09.30 | 14.12.31 | 15.03.31 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Гадаад хөрөнгө оруулалтын позиц (цэвэр)** | **-2 510** | **-9 741** | **-15 876** | **-21 425** | **-22 786** | **-23 490** | **-23 689** | **-24 061** |
| **I. Гадаад актив** | **6 846** | **5 675** | **5 548** | **3 911** | **3 136** | **3 569** | **3 437** | **3 000** |
| **1. Шууд хөрөнгө оруулалт (гадаад руу)** | **3 281** | **1 691** | **194** | **259** | **266** | **268** | **355** | **367** |
| 1.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө ба ашгийн дахин хөрөнгө оруулалт | 3 279 | 1 691 | 194 | 253 | 258 | 261 | 348 | 360 |
| 1.1.1 Салбар компаниас авах | 3 279 | 1 691 | 194 | 253 | 258 | 261 | 348 | 360 |
| 1.1.2 Салбар компанид өгөх (-) | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 1.2 Бусад хөрөнгө | 2 | 0 | 1 | 6 | 7 | 7 | 7 | 7 |
| 1.2.1 Салбар компаниас авах | 2 | 0 | 1 | 6 | 7 | 7 | 7 | 7 |
| 1.2.2 Салбар компанид өгөх (-) | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| **2. Багцын хөрөнгө оруулалт** | **56** | **28** | **474** | **324** | **291** | **285** | **280** | **288** |
| 2.1 Хөрөнгийн хувьцаа | 4 | 24 | 465 | 300 | 266 | 246 | 205 | 213 |
| 2.1.1 Төв банк | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 2.1.2 Засгийн газар | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 2.1.3 Банкууд | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 2.1.4 Бусад салбар | 4 | 24 | 465 | 300 | 266 | 246 | 205 | 213 |
| 2.2 Өрийн бичиг | 52 | 4 | 9 | 24 | 25 | 38 | 75 | 76 |
| 2.2.1 Бонд, үнэт цаас | 51 | 0 | 5 | 0 | 2 | 15 | 52 | 52 |
| 2.2.1.1 Төвбанк | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 2.2.1.2 Засгийн газар | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 2.2.1.3 Банкууд | 0 | 0 | 5 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 2.2.1.4 Бусад салбар | 51 | 0 | 0 | 0 | 1 | 15 | 52 | 52 |
| 2.2.2 Мөнгөний захын хэрэгсэл | 0 | 4 | 4 | 23 | 24 | 24 | 24 | 24 |
| 2.2.2.1 Төв банк | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 2.2.2.2 Засгийн газар | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 2.2.2.3 Банкууд | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 2.2.2.4 Бусад салбар | 0 | 4 | 4 | 23 | 24 | 24 | 24 | 24 |
| **3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл** | **6** | **0** | **0** | **5** | **5** | **2** | **9** | **1** |
| 3.1 Төв банк | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 3.2 Засгийн газар | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 3.3 Банкууд | 6 | 0 | 0 | 5 | 5 | 2 | 9 | 1 |
| 3.4 Бусад салбар | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| **4. Бусад хөрөнгө оруулалт** | **1 159** | **1 050** | **1 083** | **1 379** | **1 257** | **1 504** | **1 144** | **1 019** |
| **4.1 Худалдааны зээллэг** | 181 | 289 | 439 | 685 | 572 | 562 | 566 | 535 |
| 4.1.1 Засгийн газар | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Урт хугацааны | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Богино хугацааны | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 4.1.2 Бусад салбар | 181 | 289 | 439 | 685 | 572 | 562 | 566 | 535 |
| Урт хугацааны | 20 | 13 | 42 | 11 | 8 | 6 | 4 | 4 |
| Богино хугацааны | 161 | 277 | 398 | 675 | 564 | 556 | 562 | 531 |
| **4.2 Зээл** | 14 | 22 | 15 | 5 | 6 | 52 | 51 | 51 |
| 4.2.1 Төв банк | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Урт хугацааны | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Богино хугацааны | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 4.2.2 Засгийн газар | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Урт хугацааны | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Богино хугацааны | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 4.2.3 Банкууд | 14 | 22 | 15 | 2 | 4 | 49 | 49 | 50 |
| Урт хугацааны | 0 | 0 | 0 | 0 | 0 | 45 | 45 | 45 |
| Богино хугацааны | 14 | 22 | 15 | 2 | 4 | 4 | 4 | 4 |
| 4.2.4 Бусад салбар | 0 | 0 | 1 | 3 | 2 | 3 | 2 | 2 |
| Урт хугацааны | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Богино хугацааны | 0 | 0 | 1 | 3 | 2 | 3 | 2 | 2 |
| **4.3 Бэлэн мөнгө ба харилцах** | 964 | 739 | 628 | 689 | 678 | 890 | 527 | 433 |
| 4.3.1 Төв банк | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 4.3.2 Засгийн газар | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 4.3.3 Банкууд | 458 | 457 | 475 | 572 | 499 | 581 | 315 | 299 |
| 4.3.4 Бусад салбар | 506 | 282 | 153 | 117 | 180 | 310 | 212 | 134 |
| **4.4 Бусад актив** | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 4.4.1 Төв банк | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Урт хугацааны | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Богино хугацааны | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 4.4.2 Засгийн газар | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Урт хугацааны | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Богино хугацааны | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 4.4.3 Банкууд | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Урт хугацааны | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Богино хугацааны | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 4.4.4 Бусад салбар | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Урт хугацааны | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Богино хугацааны | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| **5. Нөөц актив** | **2 344** | **2 905** | **3 797** | **1 943** | **1 318** | **1 510** | **1 650** | **1 324** |

**Үргэлжлэл.**

| Үзүүлэлт | 11.03.31 | 12.03.31 | 13.03.31 | 14.03.31 | 14.06.30 | 14.09.30 | 14.12.31 | 15.03.31 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **II. Гадаад пассив** | **9 356** | **15 416** | **21 423** | **25 335** | **25 922** | **27 058** | **27 127** | **27 060** |
| **1. Шууд хөрөнгө оруулалт (гадаадаас)** | 5 991 | 10 763 | 14 017 | 16 022 | 16 677 | 16 843 | 16 693 | 16 607 |
| 1.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө ба ашгийн дахин хөрөнгө оруулалт | 2 547 | 4 153 | 4 984 | 5 356 | 6 003 | 6 018 | 6 078 | 6 073 |
| 1.1.1 Хөрөнгө оруулагчаас авах | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 1.1.2 Хөрөнгө оруулагчид өгөх (-) | 2 547 | 4 153 | 4 984 | 5 356 | 6 003 | 6 018 | 6 078 | 6 073 |
| 1.2 Бусад хөрөнгө | 3 444 | 6 610 | 9 033 | 10 665 | 10 674 | 10 825 | 10 615 | 10 533 |
| 1.2.1 Хөрөнгө оруулагчаас авах | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 1.2.2 Хөрөнгө оруулагчид өгөх (-) | 3 444 | 6 610 | 9 033 | 10 665 | 10 674 | 10 825 | 10 615 | 10 533 |
| **2. Багцын хөрөнгө оруулалт** | 321 | 911 | 2 683 | 2 872 | 2 876 | 2 908 | 2 913 | 2 906 |
| **2.1 Хөрөнгийн хувьцаа** | 122 | 95 | 102 | 89 | 87 | 86 | 94 | 87 |
| 2.1.1 Банкууд | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 11 | 11 |
| 2.1.2 Бусад салбар | 122 | 95 | 102 | 89 | 87 | 86 | 83 | 76 |
| **2.2 Өрийн бичиг** | 200 | 816 | 2 581 | 2 783 | 2 789 | 2 821 | 2 819 | 2 819 |
| 2.2.1 Бонд, үнэт цаас | 200 | 816 | 2 581 | 2 783 | 2 789 | 2 821 | 2 819 | 2 819 |
| 2.2.1.1 Төв банк | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 2.2.1.2 Засгийн газар | 20 | 619 | 2 080 | 2 317 | 2 317 | 1 500 | 1 500 | 1 500 |
| 2.2.1.3 Банкууд | 180 | 196 | 501 | 462 | 463 | 461 | 473 | 472 |
| 2.2.1.4 Бусад салбар | 0 | 1 | 1 | 4 | 10 | 860 | 847 | 847 |
| 2.2.2 Мөнгөний захын хэрэгсэл | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 2.2.2.1 Төв банк | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 2.2.2.2 Засгийн газар | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 2.2.2.3 Банкууд | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 2.2.2.4 Бусад салбар | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| **3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл** | 5 | 0 | 0 | 5 | 5 | 4 | 12 | 4 |
| 3.1 Төв банк | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 3.2 Засгийн газар | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 3.3 Банкууд | 5 | 0 | 0 | 5 | 5 | 4 | 12 | 4 |
| 3.4 Бусад салбар | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| **4. Бусад хөрөнгө оруулалт** | 3 038 | 3 741 | 4 723 | 6 437 | 6 363 | 7 304 | 7 508 | 7 543 |
| **4.1 Худалдааны зээллэг** | 178 | 220 | 486 | 587 | 549 | 633 | 594 | 351 |
| 4.1.1 Засгийн газар | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Урт хугацааны | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Богино хугацааны | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 4.1.2 Бусад салбар | 178 | 220 | 486 | 587 | 549 | 633 | 594 | 351 |
| Урт хугацааны | 28 | 49 | 230 | 358 | 332 | 357 | 291 | 212 |
| Богино хугацааны | 150 | 171 | 256 | 229 | 217 | 276 | 303 | 139 |
| **4.2 Зээл** | 2 739 | 3 342 | 3 627 | 4 572 | 4 552 | 5 054 | 5 165 | 5 177 |
| 4.2.1 Төв банк | 279 | 269 | 74 | 75 | 75 | 73 | 71 | 68 |
| ОУВС-гийн зээл | 279 | 269 | 74 | 75 | 75 | 73 | 71 | 68 |
| Бусад урт хугацааны | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Богино хугацааны | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 4.4.2 Засгийн газар | 1 778 | 1 914 | 2 068 | 2 188 | 2 172 | 2 096 | 2 110 | 2 056 |
| Урт хугацааны | 1 778 | 1 914 | 2 068 | 2 188 | 2 172 | 2 096 | 2 110 | 2 056 |
| Богино хугацааны | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 4.4.3 Банкууд | 195 | 253 | 337 | 680 | 698 | 796 | 904 | 900 |
| Урт хугацааны | 126 | 177 | 277 | 482 | 483 | 539 | 589 | 610 |
| Богино хугацааны | 69 | 77 | 59 | 198 | 215 | 258 | 315 | 290 |
| 4.4.4 Бусад салбар | 487 | 906 | 1 148 | 1 629 | 1 606 | 2 089 | 2 081 | 2 154 |
| Урт хугацааны | 297 | 478 | 852 | 1 404 | 1 366 | 1 813 | 1 822 | 1 902 |
| Богино хугацааны | 190 | 428 | 296 | 225 | 240 | 275 | 259 | 253 |
| **4.3 Бэлэн мөнгө ба харилцах** | 39 | 86 | 173 | 153 | 136 | 1 445 | 1 589 | 1 877 |
| 4.3.1 Төв банк | 0 | 0 | 0 | 0 | 0 | 1 302 | 1 449 | 1 773 |
| 4.3.2 Засгийн газар | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 4.3.3 Банкууд | 39 | 86 | 173 | 153 | 136 | 143 | 140 | 104 |
| 4.3.4 Бусад салбар | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| **4.4 Бусад пассив** | 82 | 94 | 437 | 1 124 | 1 127 | 172 | 160 | 138 |
| 4.4.1 Төв банк | 0 | 0 | 316 | 967 | 965 | 60 | 48 | 36 |
| Урт хугацааны | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Богино хугацааны | 0 | 0 | 316 | 967 | 965 | 60 | 48 | 36 |
| 4.4.2 Засгийн газар | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Урт хугацааны | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Богино хугацааны | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 4.4.3 Банкууд | 82 | 94 | 121 | 157 | 162 | 112 | 112 | 102 |
| Урт хугацааны | 82 | 94 | 121 | 157 | 162 | 112 | 112 | 102 |
| Богино хугацааны | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 4.4.4 Бусад салбар | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Урт хугацааны | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Богино хугацааны | **0** | **0** | **0** | **0** | **0** | **0** | **0** | **0** |

## ХАВСРАЛТ 3. МОНГОЛ УЛСЫН НИЙТ ГАДААД ӨР (сая ам.доллар)

| Үзүүлэлт | 11.03.31 | 12.03.31 | 13.03.31 | 14.03.31 | 14.06.30 | 14.09.30 | 14.12.31 | 15.03.31 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **1. Засгийн газар** | **1 798** | **1 952** | **3 568** | **3 688** | **3 672** | **3 596** | **3 610** | **3 556** |
| **1.1 Богино хугацаат** | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Харилцах, хадгаламж 5/ | | | | | | | | |
| Өрийн бичиг 4/ | | | | | | | | |
| Зээл | | | | | | | | |
| Худалдааны зээл болон урьдчилгаа | | | | | | | | |
| Бусад өглөг 6/ | | | | | | | | |
| **1.2 Урт хугацаат** | 1 798 | 1 952 | 3 568 | 3 688 | 3 672 | 3 596 | 3 610 | 3 556 |
| Зээлжих тусгай эрх (ЗТЭ), Хуваарилалт 7/ | | | | | | | | |
| Харилцах, хадгаламж 5/ | | | | | | | | |
| Өрийн бичиг 4/ | 20 | 39 | 1 500 | 1 500 | 1 500 | 1 500 | 1 500 | 1 500 |
| Зээл | 1 778 | 1 914 | 2 068 | 2 188 | 2 172 | 2 096 | 2 110 | 2 056 |
| Худалдааны зээл болон урьдчилгаа | | | | | | | | |
| Бусад өглөг 6/ | | | | | | | | |
| **2. Төвбанк** | **279** | **340** | **396** | **1 042** | **1 040** | **1 435** | **1 568** | **1 876** |
| **2.1 Богино хугацаат** | 0 | 71 | 322 | 967 | 965 | 1 362 | 1 497 | 1 809 |
| Харилцах, хадгаламж 5/ | | 71 | 322 | 967 | 965 | 1 302 | 1 449 | 1 773 |
| Өрийн бичиг 4/ | | | | | | | | |
| Зээл | | | | | | | | |
| Худалдааны зээл болон урьдчилгаа | | | | | | 60 | 48 | 36 |
| Бусад өглөг 6/ | | | | | | | | |
| **2.2 Урт хугацаат** | 279 | 269 | 74 | 75 | 75 | 73 | 71 | 68 |
| Зээлжих тусгай эрх (ЗТЭ), Хуваарилалт 7/ | 77 | 75 | 73 | 75 | 75 | 73 | 71 | 68 |
| Харилцах, хадгаламж 5/ | | | | | | | | |
| Өрийн бичиг 4/ | | | | | | | | |
| Зээл | 202 | 194 | 1 | 0 | 0 | 0 | 0 | |
| Худалдааны зээл болон урьдчилгаа | | | | | | | | |
| Бусад өглөг 6/ | | | | | | | | |
| **3. Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)** | **495** | **627** | **1 131** | **1 453** | **1 459** | **1 513** | **1 629** | **1 577** |
| **3.1 Богино хугацаат** | 69 | 77 | 59 | 198 | 215 | 258 | 315 | 290 |
| Харилцах, хадгаламж 5/ | | | | | | | | |
| Өрийн бичиг 4/ | | | | | | | | |
| Зээл | 69 | 77 | 59 | 198 | 215 | 258 | 315 | 290 |
| Худалдааны зээл болон урьдчилгаа | | | | | | | | |
| Бусад өглөг 6/ | | | | | | | | |
| **3.2 Урт хугацаат** | 426 | 550 | 1 072 | 1 254 | 1 244 | 1 255 | 1 314 | 1 287 |
| Харилцах, хадгаламж 5/ | 39 | 86 | 173 | 153 | 136 | 143 | 140 | 104 |
| Өрийн бичиг 4/ | 180 | 196 | 501 | 462 | 463 | 461 | 473 | 472 |
| Зээл | 208 | 269 | 398 | 639 | 645 | 651 | 701 | 712 |
| Худалдааны зээл болон урьдчилгаа | | | | | | | | |
| Бусад өглөг 6/ | | | | | | | | |
| **4. Бусад салбарууд** | **665** | **1 707** | **2 214** | **3 094** | **3 041** | **3 582** | **3 522** | **3 352** |
| **4.1 Богино хугацаат** | 340 | 599 | 552 | 455 | 457 | 551 | 562 | 392 |
| Харилцах, хадгаламж 5/ | | | | | | | | |
| Өрийн бичиг 4/ | | | | | | | | |
| Зээл | 190 | 428 | 296 | 225 | 240 | 275 | 259 | 253 |
| Худалдааны зээл болон урьдчилгаа | 150 | 171 | 256 | 229 | 217 | 276 | 303 | 139 |
| Бусад өглөг 6/ | | | | | | | | |
| **4.2 Урт хугацаат** | 325 | 1 108 | 1 662 | 2 640 | 2 584 | 3 031 | 2 960 | 2 961 |
| Харилцах, хадгаламж 5/ | | | | | | | | |
| Өрийн бичиг 4/ | | 581 | 581 | 878 | 885 | 860 | 847 | 847 |
| Зээл | 297 | 478 | 852 | 1 404 | 1 366 | 1 813 | 1 822 | 1 902 |
| Худалдааны зээл болон урьдчилгаа | 28 | 49 | 230 | 358 | 332 | 357 | 291 | 212 |
| Бусад өглөг 6/ | | | | | | | | |
| **5 Шууд хөрөнгө оруулалт: Компани хоорондын зээллэг** | **3 444** | **6 610** | **9 033** | **10 665** | **10 674** | **10 825** | **10 615** | **10 533** |
| Шууд хөрөнгө оруулагчид өгөх өглөг | 3 444 | 6 610 | 9 033 | 10 665 | 10 674 | 10 825 | 10 615 | 10 533 |
| Шууд хөрөнгө оруулагчийн өгөх өглөг | | | | | | | | |
| Хамааралтай компани хоорондын өглөг | | | | | | | | |
| **Нийт гадаад өр** | **6 681** | **11 237** | **16 343** | **19 942** | **19 886** | **20 951** | **20 942** | **20 895** |